

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.05.06-05.10

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал хурцдаж, АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай хаагдлаа. “Apple” компанийн хувьцааны ханш огцом унаж, S&P 500 индексийн сагсанд багтдаг мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлжээ. Мөн худалдааны маргааны асуудалтай холбоотойгоор аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш буурав. Харин өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна.

Энэ долоо хоногийн Баасан гарагт такси дуудлагын “Uber” компани IPO гарган, олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болголоо. Ингэснээр “Uber” компанийн зах зээлийн үнэлгээ 75 тэрбум ам.долларт хүрэв. Тус компани хөрөнгийн зах зээлээс ойролцоогоор 8.1 тэрбум ам. долларын хөрөнгө татан төвлөрүүлж, дэлхийн түүхэн дэхь хамгийн том 10 IPO-ийн нэг болжээ.

АНУ, БНХАУ хоёрын худалдааны асуудлаас зөрчилтэй мэдээлэл гарсаар байна. Ерөнхийлөгч ноён Дональд Трамп яриа хэлэлцээ амжилттай болно гэдэгт итгэж буйгаа илэрхийлсэн бол БНХАУ АНУ-ыг тарифаа өсгөвөл хариу арга хэмжээ авахаар анхаарууллаа. Хятадын дээд албаныхан яриа хэлэлцээ өрнүүлэхээр Пүрэв, Баасан гарагт Вашингтонд айлчлах үеэр “тохиролцож чадна” гэдэгт найдаж буйгаа АНУ-ын Ерөнхийлөгч ноён Доналд Трамп илэрхийлэв. Гэтэл АНУ Баасан гарагт Хятадын 200 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүний тарифыг одоогийн 10 хувиас 25 болгож өсгөхөө мэдэгдлээ.

Европ: Худалдааны маргааны асуудал хурцдасантай холбоотойгоор Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд буурч хаагдлаа.

Худалдааны маргаан болоод “Brexit” хэлэлцээрийн тодорхойгүй байдлаас үүдэн Их Британийн фүнтийн ханш ам. долларын эсрэг 1.3 хувиар суларчээ.

Харин еврогийн ханш ам.долларын эсрэг 1.6 хувиар чангарав. 3-р сард ХБНГУ-ын экспортын хэмжээ өнгөрсөн сараас 1.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Гэсэн хэдийн ч Европын комисс 2019 оны Европын бүсийн эдийн засгийн өсөлтийн таамгаа 1.3 хувиас бууруулж, 1.2 хувь болгов.

БНХАУ: БНХАУ-ын экспорт 4-р сард 2.7 хувиар буурсан нь шинжээчдийн таамгаас зөрсөн дүн боллоо. Тус улсын импорт 4 хувиар өссөн байна. Шинжээчид БНХАУ-ын экспорт 3 орчим хувиар өсөж, харин импорт хоёр хувь давж буурна гэсэн таамаг дэвшүүлээд байсан юм. Гадаад худалдааны тэнцэл нь 13.8 тэрбум ам.долларын ашигтай гарчээ. БНХАУ-ын гадаад худалдааны дүн шинжээчдийн таамгаас зөрж гарсан нь “Худалдааны дайн”-аас үүдэлтэй тодорхойгүй байдлын нөлөөлөл гэж зарим шинжээч тайлбарлаж байна.

Мөн БНХАУ-ын 13 их наяд ам.доллараар хэмжигдэх бондын зах зээлд дефолт зарлагсдын тоо өмнөх оноос гурав дахин өсөөд байна.

Эх сурвалж: Troweprice.com, BloombergTv.mn

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,248.24	-0.71% ▼
Dow Jones	АНУ	25,942.37	-2.12% ▼
S&P 500	АНУ	2,881.40	-2.18% ▼
Nasdaq	АНУ	7,916.94	-3.03% ▼
S&P/TSX	Канад	16,297.55	-1.19% ▼
FTSE 100	Их Британи	7,203.29	-2.40% ▼
S&P/ASX 200	Австрали	6,310.90	-0.39% ▼
Nikkei 225	Япон	21,344.92	-4.11% ▼
Hang Seng	Хонг Конг	28,550.24	-5.09% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	109.79
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	98.19
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	97.99
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.96
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.09
DBM' 2023	USD	7.250%	102.02
TDBM' 2020	USD	9.375%	103.79

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.440	-0.02 ▼
Libor 3M	2.520	-0.04 ▼
Libor 6M	2.590	-0.03 ▼
Libor 1YR	2.690	-0.06 ▼
US 2YR Bond	2.215	-0.12 ▼
US 3YR Bond	2.176	-0.12 ▼
US 5YR Bond	2.210	-0.11 ▼
US 10YR Bond	2.421	-0.10 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.05.10	Өөрчлөлт
USD	2,642.01	0.02% ▲
CNY	388.03	-1.07% ▼
EUR	2,965.79	0.56% ▲
RUB	40.53	0.22% ▲
KRW	2.25	-0.44% ▼
JPY	24.07	1.60% ▲
CAD	1,963.44	0.09% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,286.05	0.54% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	14.79	-1.03% ▼
Зэс	USD/lb.	277.45	-1.58% ▼
Нүүрс	USD/MT	87.50	-0.96% ▼
WTI газрын тос	USD/bbl.	61.66	-0.45% ▼
Brent газрын тос	USD/bbl.	70.62	-0.32% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.62	1.95% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. III	6.70%
Бодлогын хүү	2019. III	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. III	10.94%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. III	12.06%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. III	4.93%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. III	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. III	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 48 компанийн 782.7 сая төгрөгийн 5,770,572 ширхэг хувьцаа арилжигдав.


“Хөвсгөл алтан дуулга” /ADU/ компанийн хувьцаа 8.51%-аар буюу хамгийн ихээр өсөж 778.5 төгрөгт хүрч хаагдсан бол “Өндөрхаан” /ONH/ компанийн хувьцаа 26.69%-аар буурч 5,000.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 10 ширхэг үнэт цаас 1.0 сая төгрөгөөр арилжаалагджээ.


5-р сарын 10-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,374.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,248.24 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.71%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	783.7
Зах зээлийн үнэлгээ	2,374,162.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,248.24	-0.71% ▼
MSE I индекс	9,421.34	-0.27% ▼
MSE II индекс	7,891.11	-1.50% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	3,392,188	226,706,219
Ард кредит ББСБ	1,273,543	91,559,272
Тээвэр дархан	6,624	79,488,000
Даваанбулаг	463,200	70,206,720
АПУ	111,933	65,612,624

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөвсгөл алтан дуулга	778.50	8.51% ▲
Материалимпекс	8,000.00	8.25% ▲
Жинст-Увс	2,058.00	7.69% ▲
Талх чихэр	17,200.00	5.07% ▲
Айтүүлс	88.70	4.19% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Өндөрхаан	5,000.00	-26.69% ▼
Авто импекс	2,220.00	-14.62% ▼
Баялаг налайх	211.10	-14.01% ▼
Атар-Өргөө	56,000.00	-13.85% ▼
Стандарт агрикалчер групп	220.00	-12.00% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	436,703,189
Ард Секюритиз	169,221,784
Дархан брокер	159,181,412
Масдак	145,141,690
Ти Ди Би Капитал	112,327,573

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	588.08	625,824
Таван толгой	6,345.00	334,161
МИК	14,200.00	294,072
Говь	293.79	229,189
Сүү	204.00	70,176

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-15/08/20-A0295-14.5	10	1,000,000	100,000	100,000	156	14.500%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.10.01-с
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.01-с
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.12.31-ний дотор
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.29-ний дотор
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	N/A
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.12.31-ний дотор
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.05.03-ны дотор
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК I улирлын тайлан ирүүлээ

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) нь 2019 оны 3 сарын 31-нээр дуусгавар болсон 1-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан болон Хөндий Алтны Төслийн үйл явц, төлөвлөгөөг танилцуулсан байна. Тайлангаас товчлоход:

- Хөндий Алтны Төслийн Урьдчилсан ТЭЗҮ-г NI 43-101 стандартын дагуу боловсруулж эхэлсэн.
- Баян Хөндийн нөөцийг бүртгүүлж, Монгол улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн зөвшөөрлийг авсан ба ашиглалтын тусгай зөвшөөрлийг 6-р сарын сүүлээр авахаар төлөвлөн, ажиллаж байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит VII хуралдаан болж “Жинст Увс” ХК-д “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөв

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны ээлжит VII хуралдаан 5-р сарын 8-ны өдөр болж, Даатгал, Үнэт цаас, Хадгаламж зээлийн хоршоо, Хяналт шалгалт зохицуулалтын газруудын нийт 26 асуудал хэлэлцэн шийдвэрлэв.

Хуралдаанаар “Цахим” капитал ХХК-д даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн нэр бүхий төлөөлөгчдөд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо. Даатгалын салбарын 13 асуудлыг хэлэлцэж, салбар нээх зөвшөөрөл, бүтцийн болон хөрөнгийн өөрчлөлтийг бүртгэх, нэр бүхий актуарчийн даатгалын эрхийг хүчингүй болгох, албан тушаалтныг томилох зэрэг асуудлыг шийдвэрлэлээ.

Үнэт цаасны салбарын зургаан асуудлыг хэлэлцэж, “Пример дилер” ХХК-д хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, “Жинст-Увс” ХК-д “Ард санхүүгийн нэгдэл” хаалттай ХК-ийг нэгтгэхийг зөвшөөрлөө. Мөн хөрөнгийн болон хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг шийдэв.

Мөн “Давст өрнөн дэлгэрэх” ХЗХ-нд хадгаламж зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, хоёр ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгалаа.

Түүнчлэн, “Гурван булаг инвест ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг, хоёр хөдөө аж ахуйн брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээв. Мөн “Энэрэл инвест ББСБ” ХХК-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, “Норт Эйша инвестмент ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Инвескор ББСБ” Монголын хөрөнгийн бирж дээр 17.6 тэрбум төгрөгийн IPO гаргана

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит хуралдаанаар банк бус санхүүгийн салбарын тэргүүлэгч компани болох “Инвескор ББСБ”-ийн нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэж, Монголын хөрөнгийн бирж дээр IPO хийх зөвшөөрлийг олгожээ.

Инвескор ББСБ нь 2016 онд үйл ажиллагаагаа эхлүүлэн, шинэлэг шуурхай үйлчилгээ, дэвшилтэт технологийг нэвтрүүлж, харилцагчдынхаа санхүүгийн хариуцлагатай дэмжигч байх зорилт тавин ажилласаар салбартаа манлайлагчдын нэг болж чаджээ. Тус компани төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем, зээлийн үйл ажиллагааны бүрэн автоматжуулсан SMART LOS дотоод системийг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлэн, уламжлалт банк бус санхүүгийн зах зээл болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн гэсэн хоёр үндсэн тулгууртайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Мөн тус компанийн финтект технологийг хариуцсан охин компани болох “Инвескор Эй Ай Лаб” компанийн залуус Япон улсын хиймэл оюун ухааны хөгжүүлэлтээр тэргүүлэгч “Liberra” компанитай хамтран, хиймэл оюун ухаанд суурилсан кредит үнэлгээний системийг амжилттай хөгжүүлж байна. Инвескор ББСБ нь 2019 онд финтект суурилсан бичил зээлийн аппликэйшн, цахим хэтэвч, мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг холбосон шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж байгаа төдийгүй, цаашид Монгол залуусынхаа мэдлэг, ур чадварыг ашиглан Төв Ази, Зүүн Өмнөд Азийн улсуудад үйл ажиллагаагаа тэлэх зорилготой ажиллаж байна.

Инвескор ББСБ нь нийт хувьцааныхаа 15 хувь буюу 10,759,188 ширхэг хувьцааг захиалгын бүртгэлийн аргаар нийтэд санал болгон, хөрөнгийн зах зээлээс 17.6-18.7 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зорьж байна. Нийтэд санал болгох хувьцааны 85 хувийг стратегийн хөрөнгө оруулагчдад 1,650-1,750 төгрөгөөр, 15 хувийг олон нийтэд 1,550-1,650 төгрөгөөр тус тус санал болгон арилжаалах юм. Хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа 2019 оны 5 дугаар сарын 22-ноос 30-ны өдрийн хооронд зохион байгуулагдах бөгөөд татан төвлөрүүлэх хөрөнгийг зээлийн үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд зарцуулахаар төлөвлөжээ.

Тус компанийн андеррайтераар Ти Ди Би Капитал ҮЦК, туслах андеррайтераар Инвескор Капитал ҮЦК ажиллаж байна.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК ХХК

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХААБ-ийн энэ долоо хоногийн арилжааны 90 гаруй хувийг боловсруулаагүй ноолуурын арилжаа бүрдүүлээ

Баасан гарагт Хөдөө аж ахуйн бирж (ХААБ) нийт 6.8 тэрбум төгрөгийн түүхий эд арилжлаа. Ингэснээр энэ долоо хоногийн туршид 57 орчим тэрбум төгрөгийн түүхий эд арилжаад байна. Даваа гарагт арилжааны үнийн дүн бусад өдрөөс хамгийн өндөр буюу 18 орчим тэрбум төгрөгт хүрсэн бол бусад өдөр 6-13 тэрбум төгрөгийн хооронд арилжаа хийгдлээ. Энэ долоо хоногийн арилжааны 90 гаруй хувийг боловсруулаагүй цайвар болон бараан ноолуурын арилжаа бүрдүүлсэн байна. Боловсруулаагүй цайвар ноолуурын үнэ 124 орчим мянга, боловсруулаагүй бараан ноолуурын үнэ 122 мянган төгрөгт хадгалагдлаа. Энэ хоёр түүхий эдээс гадна хонины цайвар завод ноосыг Даваа болон Баасан гарагуудад арилжсан. Нийт 53 орчим тонн хонины цайвар завод ноосыг кг тутмыг нь 2,000 төгрөгөөр арилжсан. Энэ түүхий эдийн үнэ өнгөрсөн долоо хоногт тогтвортой байлаа.

Эх сурвалж: BloombergTv.mn



Нүүрсний компаниудын экспорт өссөн ч логистикийн шинжтэй асуудлууд гарсаар байна

Голлох нүүрсний компаниудын экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дийлэнх нь өссөн байна. Хэдий тийм боловч логистикийн шинжтэй асуудлууд гарсаар байгааг зарим компани онцоллоо.

Оны эхний дөрвөн сард Гашуунсухайт-Ганцмод боомтоор 5.3 сая тонн нүүрс, Шивээхүрэн-Сэхэ боомтоор 4.4 сая тонн нүүрс экспортолсон талаар Өмнөговь аймгийн Засаг дарга мэдээлсэн юм.


Шивээхүрэн-Сэхэ боомтоор нүүрс экспортолж байгаа компаниудаас Нарийнсухайтын бүлэг ордод олборлолт хийж буй "Монголын алт корпораци" оны эхний дөрвөн сард нэг сая гаруй тонн нүүрс экспортолсон байна. Энэхүү үзүүлэлт өнгөрсөн оны мөн үеэс саарчээ. Энэ нь нүүрс тээвэрлэх зөвшөөрөл авахад тавьдаг шалгуур нэмэгдсэнтэй холбоотой гэж тус компани тайлбарлаж байна. "Монголын алт корпораци" энэ онд найман сая тонн нүүрс экспортолхоор төлөвлөжээ.

Харин "Өсөх зоос" ХХК нэг сая 200 мянга орчим тонн нүүрс энэ оны эхний дөрвөн сард экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс өссөн байна. Энэ онд дөрвөн сая тонн нүүрс экспортолхоор төлөвлөж байгаа тус компани тавдугаар сард жилд 2.5 сая тонн нүүрс угаах хүчин чадалтай үйлдвэрээ ашиглалтад оруулах юм. Гэхдээ эрчим хүчний асуудал гол бэрхшээл хэвээр байна гэж үзэж байна.

Баруун Ноён уул ордод олборлолт хийж байгаа "Terracom" компани оны эхний гурван сард 230 мянган тонн нүүрс борлуулжээ. Тус компани Монголоос олборлож, борлуулах нүүрсний хэмжээгээ жилийн гурван сая тонн болгохоор зорьж байгаа аж. Тийм учраас шинэ уурхайгаас нүүрс олборлож эхэлсэн байна.

Харин Гашуунсухайт боомтоор экспорт хийж буй "Эрдэнэс Тавантолгой" ХК 2019 оны эхний гурван сард 2.4 сая тонн нүүрс экспортолжээ. Энэ онд Монгол Улс 42 сая тонн нүүрс экспортолхоор төлөвлөж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор энэ онд шинэчлэх гол боомт нь Гашуунсухайт боомт байгаа юм. Энэ жил БНХАУ-ын буцалтгүй тусламжийн нэг хэсэг болох 140 сая юань буюу 50 гаруй тэрбум төгрөгөөр бүрэн шинэчлэл хийхээр төлөвлөж байна. Одоогоор зураг төсвөө гаргаж, гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах шатандаа яваа гэдгийг Өмнөговь аймгийн Засаг дарга мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTv.mn



I-IV сард зэсийн баяжмалын экспорт 489.1 мянган тонн болж өслөө

5-р сарын байдлаар шатахууны хилийн үнэ тонн тутамдаа өмнөх сараас А-80, АИ-92 автобензин 53 ам.доллороор, дизель түлш 17 ам.доллороор өссөн нь дотоодын шатахууны үнэ өсөхөд нөлөөлж байна гэж Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ.

Ираны хориг арга хэмжээнээс шалтгаалан газрын тосны ханш сүүлийн зургаан сарын дээд түвшинд хүрээд байгааг мөн онцолсон юм. Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд шатахууны үнийг автоматаар тогтоох механизмыг нэвтрүүлэх ажлын хэсэг өнгөрсөн сард Монгол Улсад ажилласан байна. Энэ нь үнийн огцом хэлбэлзлийг бууруулж, зах зээлийн зарчимд нийцүүлэх ач холбогдолтой гэж үзэж байгаа аж.

Үүнээс гадна дотоодод газрын тос боловсруулах 1.5 сая тонны хүчин чадалтай үйлдвэр барих төслийн дэд бүтцийн ажил 80 хувьтай, графикайн дагуу явж байгаа юм байна. Газрын тосны үйлдвэрийг түүхий эдээр хангахын тулд эрэл хайгуулыг эрчимжүүлж, нөөц өсгөж, олборлолтоо нэмэгдүүлэх шаардлага үүсжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.